

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2026.08.31

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Монголбанк бодлогын хүүг 12.5% болгож нэмэгдүүллээ
- COP17 бага хурлын үр дүн
- ТОП-20 индекс түүхэн дээд түвшнээ шинэчлэн, өсөлтөө үргэлжлүүлээ
- Хаан банк ХК-ийн зах зээлийн үнэлгээ 3 их наяд төгрөгийг давлаа

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	2.11%	6.90%	6.21%
MSE A	2.87%	7.04%	6.93%
MSE B	3.85%	5.27%	5.57%
FTI	1.03%	7.33%	-

2026/08/24 – 2026/08/28

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
MGLA	4,743,478,346.20
INV	3,530,464,495.00
KHAN	937,254,565.00
APU	500,401,291.79
TTL	484,801,781.00

2026/08/24 – 2026/08/28

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
BUK	268.00	21.53%
HGN	37.00	15.63%
TUS	342.00	14.96%
QPAY	407.62	14.84%
TAV	15,200.00	14.80%

2026/08/24 – 2026/08/28

2026 он 08-р сарын 31

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

14,743

ТОП-20 индекс 57,862

MSE A 22,266

MSE B 15,162

FTI индекс 1,086



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

7.7%

2026 - II улирал

Инфляц

13%

2026-07 сар

ГВУН(сая\$)

7,962.69

2026-07 сар

Бодлогын

хүү

12.5%

ЗГ-ын бондын
өгөөж

5.7%

USD/MNT

3,595.38

2026-08-30




Эдийн засгийн мэдээлэл

МОНГОЛБАНК БОДЛОГЫН ХҮҮГ 12.5% БОЛГОЖ НЭМЭГДҮҮЛЛЭЭ

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2026 оны 8 дугаар сарын 12-нд ээлжит бусаар хуралдаж, инфляцын дарамт болон иргэдийн инфляцын хүлээлт нэмэгдэж буйтай холбоотойгоор мөнгөний бодлогыг чангаруулах шийдвэр гаргалаа. Тодруулбал, бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12.5%, банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 0.5 нэгж хувиар өсгөж 14.5% болголоо.

Монгол Улсын инфляц сүүлийн таван сар дараалан нэмэгдэж, 7 дугаар сард 13%-д хүрсэн байна. Үүний 6.5 нэгж хувийг дотоодын хүнсний бүтээгдэхүүн, 1.2 нэгж хувийг шатахуун, 0.8 нэгж хувийг төрийн зохицуулалттай бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлжээ.

График: Инфляц ба бодлогын хүүгийн өөрчлөлт



Монголбанкны энэ удаагийн шийдвэр нь хүнс, шатахууны үнийн өсөлтийг шууд бууруулах гэхээс илүүтэй нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлт эдийн засгийн бусад хэсэгт тархахаас сэргийлэх, инфляцын хүлээлтийг тогтворжуулах зорилготой байна.

СОР17 БАГА ХУРЛЫН ҮР ДҮН

СОР17-ын хүрээнд Монгол Улс ногоон хөгжил, дэд бүтэц, санхүүжилт болон технологийн чиглэлээр хэд хэдэн томоохон хөрөнгө оруулалтын боломжийг бий болгосон байна. Тухайлбал, 5 тивийн 23 улсад хэрэгжих төслүүдэд зориулан нийт 1.3 тэрбум ам.долларын санхүүжилт босгохоор болсон бөгөөд Монгол Улсын нийслэлийн ногоон төслүүдэд 400 сая ам.доллар, ногоон дата төв байгуулахад 2 тэрбум ам.доллар орчим, Дэлхийн банкнаас 100 сая ам.доллар хүртэл, Европын хөрөнгө оруулалтын банкнаас ойн аж ахуй, газрын нөхөн сэргээлтэд 200 сая евро хүртэлх санхүүжилтийн боломж нээгдэж байна.

Мөн 50 сая ам.долларын Ногоон Санхүүгийн Корпорац ба GIRAF сан байгуулагдаж, ХААН Банк 50 сая, ХасБанк 40 сая ам.долларын санхүүжилт татахаар болжээ. Түүнчлэн АНУ-ын AI чип үйлдвэрлэгч Blaize компанитай үндэсний AI дэд бүтэц хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар болсон нь технологийн салбарын хувьд онцлох үйл явдал боллоо.

Гэхдээ эдгээр нь бүгд шууд орж ирсэн хөрөнгө биш, тодорхой хэсэг нь цаашид хэрэгжих санхүүжилтийн боломж тул бодит үр дүн нь хөрөнгийг хэр үр ашигтай, ил тод зарцуулж, төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхээс шалтгаалах юм.




Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 ИНДЕКС ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШНЭЭ ШИНЭЧЛЭН, ӨСӨЛТӨӨ ҮРГЭЛЖЛҮҮЛЭЭ

Монголын хөрөнгийн зах зээлд өсөлтийн хандлага үргэлжилж, ТОП-20 индекс 57,861.73 нэгжид хүрч, оны эхний дүнгээс 3,137.85 нэгж буюу 5.7%-иар өссөн байна. Ингэснээр индекс 8 дугаар сарын 19-нөөс хойш найм дахь дараалсан арилжааны өдөр түүхэн дээд түвшнээ шинэчилжээ. Мөн MSE-A индекс 6.6%-иар өсөж 22,265.54 нэгж, MSE-B индекс 5.9%-иар өсөж 15,162.16 нэгжид хүрсэн байна.

График: ТОП-20, MSE-A, ба MSE-B индексүүдийн 2026 оны гүйцэтгэл /Суурь=100%/




Сүүлийн өдрүүдийн өсөлтийг голлон АПУ болон Хаан банкны хувьцааны ханшийн өсөлт дэмжлээ. АПУ ХК-ийн хувьцаа 1,126 төгрөгт хүрч өссөн нь сүүлийн хоёр жилийн хамгийн өндөр түвшин болж, компанийн зах зээлийн үнэлгээг 35.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Харин Хаан банк ХК-ийн хувьцаа 1,630 төгрөгт хүрснээр түүхэн дээд ханшаа шинэчилж, тус банкны зах зээлийн үнэлгээ 3.1 их наяд төгрөгт хүрчээ. Мөн Хас банк, Тавантолгой зэрэг томоохон компаниудын хувьцааны өсөлт индексийг дэмжсэн байна.

Ийнхүү Монголын хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд оны эхний хагаст уналттай байсан ч сүүлийн үед дараалан өсөж, ТОП-20 индекс түүхэн дээд түвшнээ шинэчилсэн нь эерэг хандлагыг үргэлжлүүлж байна. Гэхдээ зарим хувьцаанд огцом өсөлтийн дараах ашиг хураалт ажиглагдсан нь зах зээлийн идэвх өндөр хэвээр байгаа ч хувьцаануудын хөдөлгөөн харилцан адилгүй байгааг харууллаа.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

Ногдол ашигт суурилсан хөрөнгө оруулалт хийхэд мэдэж байх ёстой өдрүүд

Компаниудын хувьцааг эзэмшиж ногдол ашиг авахын тулд доорх өдрүүдийг зайлшгүй мэдэж байх ёстой. Монгол улсын хувьд Т+2 төлбөр тооцооны системийн дагуу гүйлгээ хийгддэг учраас бүртгэлийн өдрөөс 2 хоногийн өмнө тухайн хувьцааг худалдаж аван ногдол ашиг авах боломжтой болдог.

Зарлах өдөр /Declare date/	Хувьцаа авсан байх өдөр /Ex-Dividend date/	Бүртгэлийн өдөр /Record date/	Төлбөрийн өдөр /Payable date/
2026.02.19 өдөр ТУЗ-ийн тогтоолоор зарласан.	2026.03.20 өдөрт амжиж ХЭ болсон байх ёстой.	2026.03.22 өдөр ногдол ашиг авах эрхтэй ХЭ-н жагсаалт гаргана.	2026.04.30 өдөр ҮЦТХТ дансаар олгоно.

Энэ нь ямар нэг компанийн бодит жишээ биш бөгөөд зохиомол өдрүүд болно.